

## ГАРЧИГ

|                                                                                                                   |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....                                                                                | 2  |
| 2. 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, биелэлт .....                                    | 4  |
| 3.1. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил:.....                                          | 5  |
| 3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил .....                               | 6  |
| 3.3. Хөрс, ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд .....            | 7  |
| 3.4. Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....                               | 7  |
| 3.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....                                                        | 8  |
| 3.6. Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс .....                                                               | 9  |
| 3.7. Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....                                              | 9  |
| 3.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ..... | 9  |
| ДҮГНЭЛТ .....                                                                                                     | 14 |


## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### Төслийн товч танилцуулга

Хайлаастын дэнжийн хэсгийн алтны шороон орд нь засаг захиргааны хувьд Төв аймгийн Заамар сумын нутагт харьяалагдах бөгөөд MV-020868 дугаар бүхий ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй талбайд Улаанбаатар хотоос баруун хойш 220 км, Заамар сумын төвөөс баруун хойд зүгт 25 км-т байр зүйн зургийн М-48-126, 138 нэрэлбэрт оршино.

Хүснэгт 1. MV-020868 тоот талбайн солбицол

| №  | Уртраг |     |        | Өргөрөг |     |        |
|----|--------|-----|--------|---------|-----|--------|
|    | град   | мин | сек    | град    | мин | сек    |
| 1  | 104°   | 32' | 54.51" | 48°     | 19' | 55.83" |
| 2  | 104°   | 32' | 54.57" | 48°     | 19' | 50.17" |
| 3  | 104°   | 33' | 6.71"  | 48°     | 19' | 50.21" |
| 4  | 104°   | 33' | 6.75"  | 48°     | 19' | 43.74" |
| 5  | 104°   | 33' | 16.46" | 48°     | 19' | 43.77" |
| 6  | 104°   | 33' | 16.51" | 48°     | 19' | 38.11" |
| 7  | 104°   | 33' | 26.22" | 48°     | 19' | 38.15" |
| 8  | 104°   | 33' | 26.29" | 48°     | 19' | 30.05" |
| 9  | 104°   | 33' | 33.57" | 48°     | 19' | 30.08" |
| 10 | 104°   | 33' | 33.64" | 48°     | 19' | 23.61" |
| 11 | 104°   | 32' | 49.94" | 48°     | 19' | 23.45" |
| 12 | 104°   | 32' | 49.88" | 48°     | 19' | 29.91" |
| 13 | 104°   | 32' | 42.6"  | 48°     | 19' | 29.89" |
| 14 | 104°   | 32' | 42.58" | 48°     | 19' | 33.13" |
| 15 | 104°   | 32' | 35.3"  | 48°     | 19' | 33.1"  |
| 16 | 104°   | 32' | 35.26" | 48°     | 19' | 36.33" |
| 17 | 104°   | 32' | 31.93" | 48°     | 19' | 36.33" |
| 18 | 104°   | 32' | 31.93" | 48°     | 19' | 55.73" |



Зураг 1. Төслийн талбайн байршлын тойм зураг

Заамар сумын уур амьсгал, цаг уурын үзүүлэлтүүд

Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Төв аймгийн Заамар сумын цаг уурын “ЗААМАР” харуулын сүүлийн 10 жилийн мэдээний үндсэн дээр тодорхойлсон болно.

Агаарын температур: Агаар мандлын дулааны горим бол агаар мандал дахь температурын хуваарилалт, хувьсал өөрчлөлтийн явцаар тодорхойлогдох бөгөөд энэ нь тухайн газар нутгийн уур амьсгалын үндсэн элемент болж агаар, хүрээлэн буй орчны хоорондох дулааны солилцоогоор илэрдэг зүй тогтолтой. 2009-2019 оны агаарын жилийн дундаж температур  $-0.7-2.3^{\circ}$  байна.

**Хөрс, ургамал:** Төсөл хэрэгжих бүс нутаг нь хөрс газар зүйн ангиллын хувьд Хангайн хөрсний их муж түүн дотор Хангайн мужид тус тус хамаарна. Хангайн их мужид хамгийн түгээмэл тархсан хөрс бол хээрийн хүрэн хөрс бөгөөд орон нутгийн хөрс үүсэх өөр өөр нөхцөлөөс шалтгаалж хүрэн хөрсний хэд хэдэн дэд хэв шинж хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн, уулын хүрэн, нугын хүрэн, ойн хүрэн хөрс тус тус тархсан байна /Доржготов, 2003/

**Хүн ам, эдийн засаг:**

Төв аймгийн Заамар сум нь хүн амын суурьшил ихтэй бүс нутаг бөгөөд сумын хэмжээнд 3000 орчим хүн амтай. Халх ястан голлон амьдардаг. Голчлон газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг. Заамар район нь зам харилцаа сайтай өвөл, зуны аль ч улиралд бартаа саадгүй, аж үйлдвэр, ХАА-н үйлдвэрлэлийн баазуудад ойр байрлана. Тухайлбал Хөтөлийн цементийн үйлдвэрээс 180 км, Дархан хотоос 200 км-т, Улаанбаатар хотоос 240 км-т оршдог. Энд ХАА-н банкны салбар, шуудан холбоо, Мобикомын станц, худалдаа үйлчилгээний газрууд байрладаг. Мөн “Петровис”, “МТ” компаниудын ШТС-ууд байдаг. Тус сум нь уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж буй бүс нутаг юм.

## 2. 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, биелэлт

Тус уурхайг ил аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ашигт малтмалын газрын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг 2021 оны 6-р сарын 4-ны өдрийн Т/98 тоот тушаалаар, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу 2021 онд “Ногоон Эко Мандала” ХХК боловсруулж БОАЖЯ-аар батлуулсан.

### **2022 оны уулын ажлын төлөвлөгөө**

Уурхайн бэлтгэл ажил 2022 оны 03-р сарын 1-ээс эхлсэн бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зарим шаардлагатай засвар үйлчилгээний ажлууд хийгдсэн. Тухайн жилд ашиглах блокуудын шимт хөрсийг ялган бульдозероор түрж блокын хилийн гадна гадаад овоолгод байршуулж үндсэн хөрсийг экскаватор, автосамосвал ашиглан өмнөх жилд үүсгэсэн дотоод овоолгод шилжүүлэн байршуулахаар төлөвлөв. Орд нь харьцангуй бага гүний орд тул ашиглалтын ажилтай зэрэгцэн олборлолтын хажуугаар техникийн нөхөн сэргээлтийг хийх бөгөөд олборлосон орон зайд дотоод овоолго хийх хэлбэрээр гүйцэтгэх боломжтой байна.

2022 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр ордын 3- В', II- В', гэсэн блокуудын үлдсэн хэсгийг мөн 4-В', 5- В', 6- В', 7- В', III-В', IV-В' гэсэн блокуудыг бүхэлд нь олборлохоор төлөвлөсөн. Энэ үед уурхайн урт 920 метрээр тэлж, нэмж 5.9 га талбайг эвдрэлд оруулж байна. 2022 онд дээрх блокуудаас нийт 469.55 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, дунджаар 460 мг/м<sup>3</sup> агуулгатай 72.29 мян.м<sup>3</sup> элс олборлон баяжуулж 30.78 кг алт /химийн цэврээр/ гарган борлуулахаар байна.

### **3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

#### **3.1. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил:**

Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх зааварчилгааг тогтмол өгч мөрдүүлж ажилласан.

**Хүснэгт 2. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил**

| Д.д | Төлөвлөгөө                                                                                                                                                                                                                        | Хариуцсан<br>эзэн | Биелэлт, зарцуулсан зардал<br>мян.төг                                                                                                            |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслыг тогтоосон хугацаанд нь сольж байх. | Компанийн захирал | 250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн масло, маслын шүүр, агаар болон, түлшний шүүрүүдийг байнга сольж байсан. Үйл ажиллагааны зардалд орсон |
| 3   | Уурхайн ашиглалтын үед тоосжилт дарах зорилгоор усалгааг тогтмол хийх.                                                                                                                                                            |                   | Усалгааг тогтмол хийж байсан. Зардал нь усан орчны зардалд орсон.                                                                                |
| 4   | Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээний ажлыг хийлгэх                                                                                                                                     | Уурхайн дарга     | Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг 5, 8-р сард хийлгэсэн.                                                                 |
| 4   | Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлөх                                                                                                                |                   | Агаарын бохирдлын төлбөр 161000 төгрөг                                                                                                           |
|     | Нийт                                                                                                                                                                                                                              |                   | 161.0 мян төг                                                                                                                                    |

**3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил**

*Ус, усан орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:*

Уурхайн ус ашиглах гэрээг Туул голын сав газартай 2022 оны 05-р сарын 13-ны өдөр баталгаажуулсан. Энэ онд 24 749 000 төгрөг тушаасан болно.

### 3.3. Хөрс, ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд

#### Хүснэгт 3. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажлууд

| Д.д | Төлөвлөгөө                                                     | Хариуцсан эзэн    | Биелэлт, зарцуулсан зардал мян.төг                                                                                                    |
|-----|----------------------------------------------------------------|-------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | Газар эзэмших гэрээгээ орон нутагтай байгуулан төлбөрөө төлөх. | Компанийн захирал | 2022 оны 7-р сарын 22-нд Заамар сумын мэргэжилтэн Н.Ариунбаяртай гэрээ байгуулж баталгаажуулсан. 652402 төгрөг газрын төлбөрт төлсөн. |
|     | Нийт зардал                                                    |                   | 652.4 мян.төг                                                                                                                         |

#### Хүснэгт 4. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд

| Д.д | Төлөвлөгөө                                                                      | Хариуцсан эзэн    | Биелэлт, зарцуулсан зардал мян.төг                                                                                                |
|-----|---------------------------------------------------------------------------------|-------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | Олон салаа зам гаргахгүй байх                                                   | Уурхайн дарга     | -                                                                                                                                 |
| 2   | Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байршуулсан. | Уурхайн дарга     | Багаж хэрэгсэлд нийт 500.0 төгрөг                                                                                                 |
| 3   | Орд орчмын ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа                           | Компанийн захирал | Орд орчмын хяналт шинжилгээний ажлыг 5, 8-р сард хийж гүйцэтгэсэн бөгөөд зардал нь хяналт шинжилгээ, мониторингийн зардалд орсон. |
|     | Нийт                                                                            |                   | 500.0                                                                                                                             |

### 3.4. Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Д.д | Төлөвлөгөө | Хариуцсан эзэн | Биелэлт, зарцуулсан зардал мян.төг |
|-----|------------|----------------|------------------------------------|
|-----|------------|----------------|------------------------------------|

|   |                                                                                                                             |               |                                                                                                                                                                          |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 5.8 га талбайд дотоод овоолгоор нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн.                                                          | Уулын инженер | Төлөвлөсний дагуу тус талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Зардал нь үйл ажиллагааны зардалд орсон.                                                        |
| 2 | Шимт хөрс хадгалах хамгаалах                                                                                                |               | 1.3 мян.м <sup>3</sup> шимт хөрс хадгалах хамгаалах ажил хийгдэв.                                                                                                        |
| 3 | Сумын нутаг дэвсгэрт гар аргаар алт олборлогчдын нөлөөлөлд өртөж эвдэрсэн 5.0 га газарт нөхөн сэргээлт хийнэ.               |               | Хариуцлагатай уул уурхайн хүрээнд хууль бусаар алт олборлогчдод эвдэгдэж орхигдсон 5.7 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. 21811950 төгрөг зарцуулсан. |
| 4 | 2022 онд орон нутгийн саналын дагуу тогтоож өгсөн талбайд мод тарихаар төлөвлөв. “Тэр бум мод” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд |               | 2.5 га талбайд 1200 мод тарьсан. 9074500 төгрөг зарцуулсан.                                                                                                              |
|   | Нийт зардал                                                                                                                 |               | 30886.44 мян.төг                                                                                                                                                         |



Зураг 2. Техникийн нөхөн сэргээлт хийсэн байдал

### 3.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

**Хүснэгт 5. Хог хаягдлыг менежментээр хийгдсэн ажлууд**

| Д.д         | Төлөвлөгөө                                                                 | Хариуцсан<br>эзэн | Биелэлт, зарцуулсан зардал мян.төг                                                                |
|-------------|----------------------------------------------------------------------------|-------------------|---------------------------------------------------------------------------------------------------|
| 1           | Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан зайлуулах.     | Компанийн захирал | 2022 оны 8-р сарын 15 нд Засаг дарга Л. Амгаланбаяртай гэрээ байгуулсан. 1000000 төгрөг тушаасан. |
| 2           | Хог хаягдлын төлбөрөө төлөх.                                               |                   | Заасан газраас өөр газар хог хаяагүй.                                                             |
| 3           | Ахуйн хаягдлыг хаях цэг байгуулах.                                         |                   | Өөрийн байгууллагын эргэн тойронд 50м газрыг тогтмол цэвэрлэж байсан.                             |
| 4           | Хог хаягдлын гэрээнд заасны дагуу эзэмшил газрын ойролцоо талбайг цэвэрлэх |                   | Хотхоны зам талбай, уурхайлалтын хэсэгт гэрэлтүүлэг нэмсэн. Дотоод зардалд орсон                  |
| 5           | Орчин тойрондоо гэрэлтүүлэг хийсэн.                                        |                   |                                                                                                   |
| Нийт зардал |                                                                            |                   | <b>1000.0 мян.төгрөг</b>                                                                          |

**3.6. Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс**

Ордын ашиглалтын талбай түүний ойр орчимд түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс байхгүй болно.

**3.7. Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**

Тус төсөл нь химийн бодис ашиглаагүй.

**3.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулсан. Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажилласан.

**Хүснэгт 6. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн удирдлага**

**зохион байгуулалтын ажил**


| № | Хэрэгжүүлсэн арга хэмжээ                                                                                                                                    | Хариуцсан<br>эзэн | Тайлбар,<br>зарцуулсан<br>зардал<br>мян.төг |
|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|---------------------------------------------|
| 1 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөж ажилласан. | Уурхайн<br>дарга  | Дотоод<br>төлөвлөл<br>төөр                  |

### 3.9. Хяналт шинжилгээний ажлын биелэлт

| № | Хяналт шинжилгээний дээж | Хяналт шинжилгээний үзүүлэлт                                                                                                                                                                                                      | Хяналт шинжилгээ явуулсан хугацаа | Хяналт шинжилгээ явуулсан байршил                             | Хяналт шинжилгээ хийсэн багаж, холбогдох стандарт                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|---|--------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|---------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Агаар                    | Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, Хүхэрлэг хий, Азотын давхар исэл                                                                                                                                                 | 5, 8 сард                         | Уурхайн карьер, уурхайн зам, ажилчдын хотхон, засварын талбай | Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007<br>Агаарын чанарын стандарт MNS 4585:2016<br>Агаарын тоосжилтыг Dusttrak 8530<br>Шинжилгээний аргын стандарт, MNS 17.2.5.12:88<br>MNS 17.2.5.11:88 |
| 2 | Ус                       | Усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (pH, EC, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, pH, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , CO <sub>3</sub> , HCO <sub>3</sub> ) | 5, 8 сард                         | Гүний худаг, цэвэр бохирын нуур                               | Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2008, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус 4943:2015,                                                                                              |
| 3 | Хөрс                     | Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл (Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери                                                                                                                | 5, 8 сард                         | Шимт хөрс, засварын талбай, хотхон                            | - MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл<br>- MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох<br>- MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам<br>- MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх                                                                                                                         |

2022 оны Орчны Хяналт Шинжилгээний ажлыг тус оны 5, 8-р сард Байгаль орчны үнэлгээ, зөвлөгөөний “Ногоон Эко Мандала” ХХК хийж гүйцэтгэсэн.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, хөрс, агаарын шинжилгээг хийлгэсэн.



Зураг 3. Дээж авсан цэгийн байршил



Зураг 4. Агаарын шинжилгээ хийж байх үеийн зураг



Зураг 5. Усны шинжилгээ авч байх үеийн зураг

**Хүснэгт 9. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал**

| Д.д | Зардлын утга                                                                       | Нийт зардал,<br>мян.төг |
|-----|------------------------------------------------------------------------------------|-------------------------|
| 1   | Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал      | 161.0                   |
| 2   | Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал | 652.4                   |
| 3   | Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал              | 500.0                   |
| 4   | Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал                                    | 1000.0                  |
| 5   | Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал                        | 24749.0                 |
| 6   | Нөхөн сэргээлтийн ажлын зардал                                                     | 30886.4                 |
| 7   | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал                                       | 3000.0                  |
| 8   | Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал                                         | Дотоод зардал           |
|     | <b>2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн</b>          | <b>60948.8</b>          |

### ДҮГНЭЛТ

“Юбиксолюшн” ХХК-ийн “Хайлаастын дэнжийн /ХШ-45-57/” алтны шороон ордын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Төв аймгийн Заамар сумын нутагт байрладаг.

2022 оны 7-р сарын 22-нд Заамар сумын мэргэжилтэн Н.Ариунбаяртай гэрээ байгуулж баталгаажуулж 650402 төгрөг төлсөн.

Уурхайн ус ашиглах гэрээг Туул голын сав газартай 2022 оны 05-р сарын 13-ны өдөр байгуулсан. 24749770 төгрөг төлсөн.

5.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн бөгөөд Зардал нь үйл ажиллагааны зардалд орсон.

Дүйцүүлэн хамгаалах ажлын хувьд Юбиксолюшн ХХК нь 2022 онд орон нутгийн саналын дагуу эвдэгдэж орхигдсон 5.7 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Мөн тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2.5 га талбайд 1200 мод тарималжуулсан.

2022 оны Орчны Хяналт Шинжилгээний ажлыг тус оны 5,8-р сард Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний эрх бүхий “Ногоон Эко Мандала” ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн. Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, агаарын тоосжилт, хөрс, усны шинжилгээ хийсэн.

2022 оны 10-р сарын байдлаар Нийт 2022 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **60.9 сая төгрөг** зарцуулсан байна.